



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 4/08

Бор-Өндөр сум

**Албан тушаалын тодорхойлолт батлах
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-ын 5.1 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр хавсралт, Малын үржил бүртгэл, мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар хавсралт, Бэлчээр газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Албан тушаалын тодорхойлолтуудыг хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн (Ц.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

ДАРГА



З.УУГАНЖАРГАЛ